



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурал хүчин төгөлдөр болсныг батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “АСБИ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчдээс 4 хувьцаа эзэмшигч холбогдсон нь нийт саналын эрхтэй хувьцааны 94.03% (59,670 ширхэг) болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН



 Б.ДОРЖСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудал
тус бүрийн саналын дүнг нэгтгэн батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт болон үйл ажиллагааны тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх: Санал хураалтын дүнгээр 100% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал хураалтын дүнгээр зөвшөөрсөн 100% байх тул шийдвэр хүчинтэйд тооцугай.
3. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2022 оны зардлын төсөв батлах санал хураалтын дүнгээр зөвшөөрсөн 100% байх тул шийдвэр хүчинтэйд тооцугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН



 Б.ДОРЖСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 0/

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон АСБИ ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн саналыг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



D. J. Khagvasuren

Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг
сонгох тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь хэсэг, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж дор дурьдсан хүмүүсийг ажиллуулахаар баталсугай.

ТУЗ-ын ердийн гишүүнд

- 1.1 Д.Лхагвасүрэн ✓
- 1.2 Л.Сүмбанд ✓
- 1.3 Ч.Дашцэрэн ✓
- 1.4 С.Буман-Ордэнэ ✓
- 1.5 Б.Доржсүрэн ✓
- 1.6 С.Бат-Эрдэнэ

ТУЗ-ын хараат бус гишүүнд

- 1.7 Э.Буянтогтох ✓
- 1.8 Л.Нямдаваа ✓
- 1.9 Ц.Хадаа ✓

2. Компанийн үр ашгийг дээшлүүлж, үйл ажиллагааг идэвхижүүлэх, менежментийг сайжруулах, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянаж, туслах чиглэлээр идэвхи гарган ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсөв батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, 62.1.15 дахь заалт, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын 2022 оны төсвийг 8,000,000 /найман сая/ төгрөгөөр тогтоосугай.
2. Төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



[Signature]
Д.ЛХАГВАСҮРЭН